



Gunston ба Jefferson сургуулийн 8-р ангид сурдаг сурагчийн эцэг эх/асран хамгаалагч танаа:

АНС нь элсэлт багтаамжаас хэтэрч байгаа болон/эсвэл сүүлийн хоёр хичээлийн жилд элсэлт багтаамжаас хэтэрч байсан, ойрын сургууль нь нэмэлт сурагч авах багтаамжтай сургуулиудад 2021 оны Намрын улиралд харъяалал зохицуулах ажиллагааг хийж байна.

Энэхүү захидлыг хүүхэд нь Gunston or Jefferson сургуулийн 8-р ангид сурдаг бөгөөд харъяалал дахин хуваарилах төлөвлөгөөнд багтсан хэсэгт амьдардаг сурагчдын ар гэрийнхэнд зориулав. 9-11-р ангийн сурагчдын ар гэрийнхэнд өөр захидал явуулна.

АНС нь дараах [төлөвлөлтийн хэсгүүдийг](#) Wakefield ахлах сургуулиас Washington-Liberty ахлах сургуульруу хуваарилахаар төлөвлөж байна: 46110, 46120, 46111, 48160, 48180, 48290, 46140, 48150, 48280, 48281. Энэхүү өөрчлөлт нь 2022-23 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэнэ. **Энэхүү харъяаллын дахин төлөвлөлт нь одоо 8-р ангид суралцаж буй бүх сурагчид болон шинээр болон ирээдүйд элсэн орох бүх сурагчдад хамаарна.** Хоёр хэлний хөтөлбөрт хамрагддаг одоо 8-р ангид суралцаж буй сурагчид тухайн хөтөлбөртөө Wakefield дээр хамрагдах ба энэ өөрчлөлт нөлөөлөхгүй. Wakefield сургуульд одоо 9-11-р ангид сурч буй сурагчид Wakefield сургуульдаа суралцах эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн (шинээр харъяалагдсан ахлах сургуульдаа) Washington-Liberty сургуульд суралцах боломжтой.

Бид дараах шалтгаанаар таньтай холбоо барьж байна:

- Төлөвлөж буй өөрчлөлтүүдийн талаар танд мэдэгдэх;
- Тус төлөвлөгөөний талаар нэмэлт мэдээлэл авах болон асуулт асуух уулзалтын талаарх мэдээллийг өгөх;
- Сургуулийн Зөвлөлийн шийдвэрийн хуваарийг танилцуулах; болон
- Танаар Урьдчилсан шийдвэрийн маягт бөглүүлэх. Холбоос бүхий имэйлийг тусад нь явуулах ба цаасан хуулбарыг Gunston ба Jefferson сургуулийн төв оффисоос авах боломжтой.

Урьдчилсан шийдвэрийн маягтын (Letter of intent form) зорилго нь энэхүү харъяаллын дахин төлөвлөлтийн талаарх мэдээллийг таныг авсан болохыг баталгаажуулан энэхүү төлөвлөлтийн хүрээнд 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн одоо 8-р ангид сурдаг сурагчид Washington-Liberty ахлах сургуульд суралцаж эхлэхийг мэдэгдэх явдал юм.

Чөлөөлөгдөх эрх, Шинэ сурагч, Ах эгч дүү, Тээврийн мэдээлэл

- **Чөлөөлөгдөх:** Одоо Wakefield сургуульд 9-11-р ангид сурч буй сурагчдад энэхүү дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн Wakefield сургуульдаа 12-р ангиа төгстөл үргэлжлүүлэн суралцах эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн шинээр харъяалагдсан (Washington-Liberty) сургуульд суралцах боломжийг олгох саналыг АНС-н ажилтнууд гаргаж байгаа.
- **Шинэ сурагчид:** Дахин төлөвлөлтөнд багтсан хэсэгт амьдардаг, 2022 оны 6-р сарын 17-оос хойш АНС-д элсэн орох сурагч Washington-Liberty ахлах сургуульд суралцана.

- **Ах эгч дүү:** Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, одоо Wakefield сургуулийн 9-11-р ангид сурдаг сурагчийн дүү нар чөлөөлөгдөх эрхгүй ба ахлах сургуульд элсэхдээ (шинээр харъяалагдсан) Washington-Liberty сургуульд орно.
- **Тээвэр:** Одоо 8-р ангид сурч буй сурагчид 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Washington-Liberty сургуульд элсэн ороход нь АНС-н тээврийн үйлчилгээг олгох ба дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг 9-11-р ангийн сурагчдад Wakefield сургуульд үргэлжлүүлэн суралцах эсвэл (шинээр харъяалагдсан) Washington-Liberty сургуульд явах сонголт хийснээс үл хамааран үргэлжлүүлэн олгоно. Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, Wakefield сургуульд үргэлжлүүлэн суралцах 9-11-р ангийн сурагчдад сурагавтобусны [хаб зогсоолоор](#) дамжуулан тээврийн үйлчилгээ үзүүлнэ.

Ар гэрийнхэнтэй уулзах хуваарь

| Ар гэрийнхэнтэй виртуал уулзалт хийх хуваарь | | |
|---|------------------------|-------------------------|
| | Огноо | Цаг |
| Уулзалт 1 | 2021 оны 10-р сарын 16 | 11:00 а.м. – 11:45 а.м. |
| Уулзалт 2 | 2021 оны 10-р сарын 19 | 12:00 р.м. – 1:30 р.м. |
| Уулзалт 3 (Зөвхөн Испани хэлээр, Англи хэл байхгүй) | 2021 оны 10-р сарын 20 | 7:00 р.м. – 7:45 р.м. |
| Уулзалт 4 | 2021 оны 10-р сарын 21 | 7:00 р.м. – 7:45 р.м. |

Ар гэрийнхэнтэй хийх виртуал уулзалтын талаарх мэдээлэл

- Эдгээр уулзалтын холбоосыг дараах хаягнаас авна уу <https://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process/>.
- Уулзалт дүүссаны дараа бичлэгийг нь онлайнар тавина.
- Ар гэрийнхэнтэй хийх виртуал уулзалт бүр дээр нэг ижил мэдээлэл хүргэнэ.
- Хурал дээр Амхарик, Араб, Монгол, Испани хэлээр хэлмэрчлэнэ.

| Виртуал Ажлын Цагийн Хуваарь | |
|------------------------------|-------------------------|
| Огноо | Цаг |
| 2021 оны 10-р сарын 26 | 7:00 р.м. – 7:30 р.м. |
| 2021 оны 10-р сарын 28 | 12:00 р.м. – 12:30 р.м. |

Виртуал Ажлын Цагийн Мэдээлэл

- Ажлын цагаар ар гэрийнхэн асуулт асуувал асуултанд даруй хариулна.
- Уулзалтын үеэр асуусан зарим асуултын хариултыг Нийтлэг асуудаг асуулт болгон онлайн дээр тавьж болно.
- Энэ хоёр ажлын цагийн уулзалтын үеэр Испани хэл дээр хэлмэрч ажиллана.

| Харъяаллын дахин төлөвлөлтийн цагийн хуваарь | |
|--|--|
| Огноо | Үйл ажиллагаа |
| 2021 оны 10-р сарын 15-31 | Ар гэрийнхэнтэй уулзах |
| 2021 оны 11-р сарын 16 | Суперинтендентийн харъяаллын дахин төлөвлөлтийн саналыг Сургуулийн Зөвлөлд танилцуулна |
| 2021 оны 11-р сарын 30 | Харъяаллын дахин төлөвлөлтийн талаар Сургуулийн Зөвлөл нээлттэй хуралдана |

| | |
|-----------------------|--|
| 2021 оны 12-р сарын 2 | Суперинтендентийн харъяаллын дахин төлөвлөлтийн саналын талаар Сургуулийн Зөвлөл Шийдвэр гаргана |
|-----------------------|--|

2021 оны Намрын Харъяаллын дахин төлөвлөлтийн үйл явцын талаарх мэдээллийг www.apsva.us/engage/fall-2021-boundary-process хаягаар авна уу. Нэмэлт мэдээлэл, асуулт байвал engage@apsva.us хаягаар имэйл бичнэ үү.

Хүндэтгэсэн,

Лиса Стенгле
Гүйцэтгэх Захирал
Арлингтон Нийтийн Сургуулиуд